



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

“ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН” УТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Т.ТӨРМӨНХ ТАНАА

2017.02.16 № 3/98
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн" УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН” УТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга, тэргүүлэх аудитор
С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг:

Аудитын менежер: Н.Золзаяа

Утас: 260512

Цахим хаяг:

Ахлах удитор: Д.Ганбилэг

Утас: 260512

Цахим хаяг:

Хаяг: Үндэсний аудитын газар,
ЗГ-ын 4 дүгээр байр, Багатойруу-3,
Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар-15160

Монгол улс

“Баян суварга Аудит” ХХК-ий захирал

С.Должинсүрэн

Утас: 99126723

Цахим хаяг: doljinsuren9@yahoo.com

Аудитор: Х.Тунгалагтуяа

Утас: 99176599

Цахим хаяг: h.tungalagtuya@yahoo.com

Аудиторын туслах:

Ц.Эрдэнэчулуун

Утас: 94080717

Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо

Энхтайваны өргөн чөлөө, ЭДО хаус

64 201 тоот

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1.	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2.	Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4.	Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	4
5.	Дотоод хяналт.....	5
6.	Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлтийн талаар.....	5
7.	Шилэн дансны мэдээлэл.....	6
8.	Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	6
9.	Гол, онцлог гүйлгээний талаар.....	6
10.	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	6
11.	Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	8
12.	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
13.	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	8
14.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	8
15.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
16.	Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт.....	9

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/344/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг Үндэсний аудитын газрын захиалгаар 2017 оны 2 дугаар сарын 01-нээс 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд “Баян суварга аудит” ХХК-ий аудиторууд хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр “Баян суварга аудит” ХХК-д ирүүлсэн байна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Харин БСШУС-ын 2016 оны А/319 дүгээр тушаалаар “Шинжлэх ухаан, технологийн төслийн төсөвт өртөг, зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” /ХҮСХХ/ УТҮГ нь шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх, сургалт, судалгаа явуулах, хөдөө орон нутагт малын гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг дунд үйлдвэрийг бий болгох, тэдгээрт тохирсон бага оврын техник, тоног төхөөрөмжийг зохион бүтээх, үйлдвэрлэх, ноос, ноолуурын түүхий эд болон нэхмэл бүтээгдэхүүнд үндэсний стандарт MNS-62, олон улсын ISO-28, IWTO-2, AATC-5, Woolmark-13 зэрэг нийт 114 стандартын дагуу чанарын сорил, шинжилгээг гүйцэтгэдэг хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухааны олон талт үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын захирал төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын явцад төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг байгууллагынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан нийт 21 сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2016 оны нийт зардлын гүйцэтгэлийг суурь болгон авч, түүний 2 хувиар тооцон материаллаг байдлын түвшинг 13.6 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-1/

“Шинжлэх ухаан, технологийн сан”-гаас Монгол Улсын Төсвийн тухай, НББ-ийн тухай хууль болон УСНББОУС-ын дагуу 2015 онд боловсруулан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай

асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн тооцоолохын програм ашиглан санхүүгийн тайланг боловсруулж гаргасан байна.

Тав. Дотоод хяналтын талаар

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын захирлын 2016 оны 21 дүгээр тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, шилжилт хөдөлгөөн, хөрөнгө актлаж устгах, худалдан борлуулах, үнэлгээ тогтоох, хөрөнгийн тооллогын дүнг хэлэлцэж шийдвэр, дүгнэлт гаргах үүрэгтэй ажиллаж байна.

Тус зөвлөл байгуулагдсан даруйд “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” Засгийн газрын 2015 оны 439 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2016 оны 126 дугаар тушаалын дагуу ХҮСХХ-ийн хөрөнгийн тооллого явуулж, улмаар төрийн өмчийн байр, туршилтын үйлдвэр, зарим тоног төхөөрөмж, авлага зэрэг маргаантай асуудлуудыг шийдвэрлүүлэхээр ШУТИС, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт санал хүргүүлсэн боловч тодорхой шийдвэр өгөөгүй байна. Харин ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 04 дүгээр тогтоолоор тус хүрээлэнд бүртгэлтэй Нано боловсруулалттай даавуу үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг ШУТИС-ийн Үйлдвэрийн технологийн сургуулийн үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэхээр шийдвэрлэсэн байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ 2016 онд нийт 422.3 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй, үүнээс улсын төсвөөс урсгал төсвийн санхүүжилтэд 420.8 сая, нэмэлт санхүүжилтээр 80.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 1.3 сая төгрөгийн орлого хүлээн авч, төсвийн нийт гүйцэтгэлээр 422.1 сая төгрөг зарцуулж, 0.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөвт зардлын санхүүжилт болон төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг сар тутам гаргаж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 0.2 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

БСШУ-ны сайдын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар тус хүрээлэнгийн төслөөс олох нэмэлт орлого, зардлын төсвийг нийт 277.8 сая төгрөгөөр баталсан боловч хүрээлэн 2016 онд 80.6 сая төгрөгийн орлого олж бүрэн зарцуулсан байна.

Долоо. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:

- БСШУЯ-наас шилэн дансны шинэ цахим хуудас [/www.shilendans.gov.mn/](http://www.shilendans.gov.mn/)-т нэвтрэн 2015, 2016 оны мэдээллүүдийг яаралтай оруулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 4/1021, 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 4/2931 дугаар албан бичгийн дагуу холбогдох мэдээллүүдийг байршуулж, санхүүгийн тайлан, 2016 оны төсвийн төсөл зэргийг байршуулж олон нийтэд ил тод мэдээлж байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 32 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 21 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаар

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, ЭМД, НДШ, ХХОАТ болон бараа, ажил үйлчилгээний зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тус хүрээлэнд нийт 198.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл /*үүнээс нийт 117.0 сая төгрөгийн төсөвтэй 2 төсөл 2016-2018 онд хэрэгжих*/ хэрэгжиж байгаа бөгөөд 2016 онд төслийн санхүүжилтээр нийт 80.7 сая төгрөг зарцуулсан байна.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-т мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны харилцах дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээг түүврийн сорилоор анхан шатны баримт руу хөөн шалгаж үзэхэд зарлагын нийт 4 гүйлгээний 1.4 сая төгрөгийн ажил гүйлгээний баримтын бүрдэл дутуу байсныг аудитын явцад зөрчлийг арилгуулж баримтын бүрдлийг хангуулсан болно.

Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.6-д “анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 7.7-д “анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 19 дүгээр зүйлийн 19.1.5-д “эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.6, 19 дүгээр зүйлийн 19.1.5 дугаар заалтын дагуу мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг хүрээлэнгийн удирдлагад зөвлөмж болгох.

2. Тус хүрээлэн 2016 оны эцэст 57,132.0 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан боловч холбогдох этгээдтэй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Энэхүү авлага нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор ШУТИС-ийн харъяа Нэхмэлийн хүрээлэнг Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнтэй нэгтгэсэнтэй холбоотойгоор ШУТИС-ийн Ректорын 2015 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн А/81 дугаар тушаалаар Нэхмэлийн хүрээлэнгийн өөрийн орлогын ХХБ дахь 406001118 дугаар харилцах дансны үлдэгдэл 57,132.0 мянган төгрөгийг ШУТИС-ийн харъяа Үйлдвэр технологийн сургуулийн Голомт банкин дахь 8115007021 дугаар дансанд шилжүүлснийг авлагаар бүртгэж тайлагнасантай холбоотой байна. Тус хүрээлэнгийн удирдлага, Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс уг авлагыг барагдуулах талаар ШУТИС-ийн удирдлагад удаа дараа хандсан боловч тодорхой шийдвэр өгөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршиж байх /ОБ/, санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх /ЭҮ/ зэрэг санхүүгийн тайлагналын батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дугаар заалтыг хэрэгжүүлж, дээр дурдсан авлагатай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр ШУТИС-ийн Удирдах зөвлөлд Албан шаардлага хүргүүлэх.

3. Тус хүрээлэнгийн захирлын 2016 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 27 дугаар тушаалаар 2000-2005 оны эрдэм шинжилгээний төслүүд болон загварын үзэсгэлэнд зориулан оюутнуудын хийсэн ноос, ноолууран

бүтээгдэхүүнээс актлаж устгах 20 нэр төрлийн нийт 2,896.8 мянган төгрөгийн бараа материалыг устгалд оруулж данс бүртгэлээс хасахыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлд даалгасны дагуу актлаж данснаас хассан боловч Устгалын акт үйлдээгүй байна.

Аудитын явцад аж ахуйн нярвын хариуцлагад хадгалагдаж байгаа туршилтын бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэлд хяналтын тооллого хийсэн. Тооллогоор байвал зохих 59 нэр төрлийн 568 ширхэг буюу нийт 10,568.0 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн байхаас 475 ширхэг буюу 9,043.4 мянган төгрөгийн бүтээгдэхүүн тоологдсон. Угаалганд буюу дахин боловсруулалтад нийт 858.0 мянган төгрөгийн 32 ширхэг, үзэсгэлэнд тавихаар 23 ширхэг буюу нийт 159.8 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг тус тус шилжүүлж, борлуулах зориулалтаар 38 ширхэг буюу нийт 524.7 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг олгосон боловч холбогдох хүмүүстэй тооцоо хийж орлогыг төвлөрүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Цаашид бараа материалыг актлаж данснаас хасахдаа Устгалын акт үйлдэж бүртгэл тайланд тусгаж байх,

2. Борлуулахаар олгосон 524.7 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүний тооцоог холбогдох хүмүүстэй хийж орлогыг харилцах дансанд тушаалгах арга хэмжээ авч, бараа материалын хадгалалт хамгаалалт, зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг хүрээлэнгийн удирдлагад зөвлөмж болгох.

4. “Арьс шир боловсруулах өндөр технологийн инкубатор төсөл”-ийн ТЭЗҮ-ийг өөрсдийн санаачилгаар 2012 онд боловсруулан санхүүжилтийн эх үүсвэрийг гэрээ байгуулан БШУЯ-наас 105 сая, БОНХЯ-аас 192.5 сая, ШУТИС-иас 87.4 сая төгрөг буюу нийт 385.5 сая төгрөгийн санхүүжилт авч, уг төсөл 2012-2015 онд хэрэгжиж дууссан байна. Гэвч уг төслийн гүйцэтгэлийг албан ёсоор дүгнэж хүлээн аваагүй, нийт 13 төрлийн 262.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг хүлээн авч хөрөнгийн дансанд бүртгэж аваагүй байна.

Мөн тус хүрээлэнгийн инженер техник, эрдэм шинжилгээний ажилтнуудын ШБОС гаргаж үйлдвэрлэсэн лабораторийн багаж, шүрших машин зэрэг 7 нэр төрлийн 11.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг орлогод авч бүртгэлд тусгаагүйгээр ашиглаж байна.

Дээрх асуудлыг тус хүрээлэнгээс 2016 оны 6, 11 дүгээр сард ТӨБЗГ-т албан ёсоор мэдэгдсэн боловч асуудлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршиж байх /ОБ/, санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх /ЭҮ/ зэрэг санхүүгийн тайлагналын батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 1. “Арьс шир боловсруулах өндөр технологийн инкубатор төсөл”-ийн төслийн гүйцэтгэлийг албан ёсоор дүгнэж, нийт 13 төрлийн 262.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг хүлээн авч хөрөнгийг данс бүртгэлд тусгах, мөн лабораторийн багаж, шүрших машин зэрэг 7 нэр төрлийн 11.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг орлогод авч бүртгэлд тусгуулахаар тус хүрээлэнгийн удирдлагад Албан шаардлага хүргүүлэх.

5. Тус хүрээлэнгийн дэргэд 2015 оны 4 дүгээр сард байгуулагдсан монгол хонины ноосоор барилгын дулаалгын материал үйлдвэрлэх зориулалт бүхий “Гарааны ноосон дулаалга” ХХК ажиллуулж байна. Компани хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 76.3 сая төгрөгийн үйлдвэрийн барилга, 366.0 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, аж ахуйн эд хогшлыг ашиглаж, цахилгаан, дулааны зардлыг ХҮСХХ хариуцаж байгаа бөгөөд хөрөнгө ашиглах, эзэмших талаар гэрээ хэлцэл байгуулаагүй байна.

Энэ нь “Инновацийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь оюуны өмчийн эзэмшигч байх, эсвэл түүний эзэмшигчтэй лицензийн гэрээ байгуулсан байх”, 17 дугаар зүйлийн 17.1.4-д “төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын лабораторийн тоног төхөөрөмжөөр инновацийн үйл ажиллагааг дагнан эрхлэх компанид хөнгөлөлттэй нөхцлөөр үйлчилгээ үзүүлэх асуудлыг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна”, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 374 дүгээр тогтоолоор баталсан журмын 3 дугаар зүйлийн 3.5-д “Гарааны компани нь энэ журмын 2.1-д заасан эрдэм шинжилгээний байгууллагатай лицензийн гэрээг байгуулах . . .”, 3.6-д “Гарааны компанийг үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд үүсгэн байгуулах гэрээ байгуулна. Энэхүү гэрээнд хамтарч ажиллах зарчим, хүлээх үүрэг, дүрмийн сан бүрдүүлэх, оюуны өмчийг эзэмших, ашиглах, технологийн нууцлалыг хадгалах зэрэг асуудлыг тохиролцон тусгасан байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 1. “Инновацийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 17 дугаар зүйлийн 17.1.4, Засгийн газрын 2014 оны 374 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлж “Гарааны ноосон дулаалга” ХХК-тай гэрээ байгуулж ажиллахыг хүрээлэнгийн удирдлагад зөвлөмж болгох.

Арван нэг. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар санхүүгийн тайланд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 332.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад 1.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 330.9 сая төгрөгийн зөрчилд 2 Албан шаардлага өгч, дээр дурдсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 3 зөвлөмж өгсөн болно.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газраас аудитын түүврийн сорилд хамруулсан бөгөөд бие даасан зөвлөмж өгөөгүй байна.

Арван зургаа. Зөрчилгүй санал дүгнэлт

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

“ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН” УТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

Асуудал 1

Мөнгөн хөрөнгийн талаар хуудас 3

Асуудал 2

Бараа материалын талаар хуудас 4

Асуудал 3

Хөрөнгийн эзэмшлийн талаар хуудас 5

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

- Цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлууд;
- Удирдлагын анхаарах шаардлагатай асуудлууд;

Асуудал 1 Мөнгөн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол № 2

ҮАГ-ын ажиглалт

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны харилцах дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээг түүврийн сорилоор анхан шатны баримт руу хөөн шалгаж үзэхэд зарлагын нийт 4 гүйлгээний 1.4 сая төгрөгийн ажил гүйлгээний баримтын бүрдэл дутуу байсныг аудитын явцад зөрчлийг арилгуулж баримтын бүрдлийг хангуулсан болно.

Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.6-д “анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 7.7-д “анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 19 дүгээр зүйлийн 19.1.5-д “эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт суларч, хууль эрхийн акт зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмжүүд

“Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.6, 19 дүгээр зүйлийн 19.1.5 дугаар заалтын дагуу мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 6 дугаар сарын 25-ны дотор “Баян суварга Аудит” ХХК-д ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

Тус хүрээлэнгийн захирлын 2016 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 27 дугаар тушаалаар 2000-2005 оны эрдэм шинжилгээний төслүүд болон загварын үзэсгэлэнд зориулан оюутнуудын хийсэн ноос, ноолууран бүтээгдэхүүнээс актлаж устгах 20 нэр төрлийн нийт 2,896.8 мянган төгрөгийн бараа материалыг устгалд оруулж данс бүртгэлээс хасахыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлд даалгасны дагуу актлаж данснаас хассан оловч Устгалын акт үйлдээгүй байна.

Аудитын явцад аж ахуйн нярвын хариуцлагад хадгалагдаж байгаа туршилтын бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэлд хяналтын тооллого хийсэн. Тооллогоор байвал зохих 59 нэр төрлийн 568 ширхэг буюу нийт 10,568.0 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн байхаас 475 ширхэг буюу 9,043.4 мянган төгрөгийн бүтээгдэхүүн тоологдсон. Угаалганд буюу дахин боловсруулалтад нийт 858.0 мянган төгрөгийн 32 ширхэг, үзэсгэлэнд тавихаар 23 ширхэг буюу нийт 159.8 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг тус тус шилжүүлж, борлуулах зориулалтаар 38 ширхэг буюу нийт 524.7 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг олгосон боловч холбогдох хүмүүстэй тооцоо хийж орлогыг төвлөрүүлээгүй байна.

Эрсдэлүүд

Бараа материалын тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналт суларч, хөрөнгийн ашиглал, шамшиглал үүсэх.

ҮАГ-ын зөвлөмжүүд

1. Цаашид бараа материалыг актлаж данснаас хасахдаа Устгалын акт үйлдэж бүртгэл тайланд тусгаж байх,
2. Борлуулахаар олгосон 524.7 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүний тооцоог холбогдох хүмүүстэй хийж орлогыг харилцах дансанд тушаалгах арга хэмжээ авч, бараа материалын хадгалалт хамгаалалт, зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 6 дугаар сарын 25-ны дотор “Баян суварга Аудит” ХХК-д ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

Тус хүрээлэнгийн дэргэд 2015 оны 4 дүгээр сард байгуулагдсан монгол хонины ноосоор барилгын дулаалгын материал үйлдвэрлэх зориулалт бүхий “Гарааны ноосон дулаалга” ХХК ажиллуулж байна. Компани хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 76.3 сая төгрөгийн үйлдвэрийн барилга, 366.0 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, аж ахуйн эд хогшлыг ашиглаж, цахилгаан, дулааны зардлыг ХҮСХХ хариуцаж байгаа бөгөөд хөрөнгө ашиглах, эзэмших талаар гэрээ хэлцэл байгуулаагүй байна.

Энэ нь “Инновацийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь оюуны өмчийн эзэмшигч байх, эсвэл түүний эзэмшигчтэй лицензийн гэрээ байгуулсан байх”, 17 дугаар зүйлийн 17.1.4-д “төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын лабораторийн тоног төхөөрөмжөөр инновацийн үйл ажиллагааг дагнан эрхлэх компанид хөнгөлөлттэй нөхцлөөр үйлчилгээ үзүүлэх асуудлыг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна”, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 374 дүгээр тогтоолоор баталсан журмын 3 дугаар зүйлийн 3.5-д “Гарааны компани нь энэ журмын 2.1-д заасан эрдэм шинжилгээний байгууллагатай лицензийн гэрээг байгуулах . . .”, 3.6-д “Гарааны компанийг үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд үүсгэн байгуулах гэрээ байгуулна. Энэхүү гэрээнд хамтарч ажиллах зарчим, хүлээх үүрэг, дүрмийн сан бүрдүүлэх, оюуны өмчийг эзэмших, ашиглах, технологийн нууцлалыг хадгалах зэрэг асуудлыг тохиролцон тусгасан байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төрийн мэдлийн өмч хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглах, хөрөнгийн бүртгэл, тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах.

ҮАГ-ын зөвлөмжүүд

“Инновацийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 17 дугаар зүйлийн 17.1.4, Засгийн газрын 2014 оны 374 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлж, “Гарааны ноосон дулаалга” ХХК-тай гэрээ байгуулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 6 дугаар сарын 25-ны дотор “Баян суварга Аудит” ХХК-д ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТУГ-ЫН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	-	-
АВЛАГА	57,132,000.00	57,132,000.00
Бусад авлага	57,132,000.00	57,132,000.00
БАРАА МАТЕРИАЛ	33,780,034.36	34,749,144.36
Түүхий эд материал	7,581,955.59	7,581,955.59
Бэлэн бүтээгдэхүүн	19,267,820.00	10,586,000.00
Хангамжийн материал	6,930,258.77	16,581,188.77
Мал, амьтад		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,912,034.36	91,881,144.36
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	856,674,095.67	678,448,329.40
Биет хөрөнгө	855,688,095.65	677,616,329.34
Барилга, байгууламж	221,836,141.49	221,836,141.49
Хуримтлагдсан элэгдэл	(78,066,848.48)	(84,445,994.24)
Авто тээврийн хэрэгсэл	18,753,179.40	18,753,179.40
Хуримтлагдсан элэгдэл	(18,753,179.40)	(18,753,179.40)
Машин, тоног төхөөрөмж	1,001,164,432.12	1,025,771,432.12
Хуримтлагдсан элэгдэл	(305,109,320.35)	(498,731,414.96)
Тавилга, аж ахуйн эд хогшил	39,348,197.61	40,166,917.61
Хуримтлагдсан элэгдэл	(23,484,506.74)	(26,980,752.68)
Номын фонд	293,000.00	293,000.00
Бусад хөрөнгө	140,000.00	140,000.00
Хасагдуулга	(140,000.00)	(140,000.00)
Биет бус хөрөнгө	693,000.02	539,000.06
Програм хангамж	770,000.00	770,000.00
Хасагдуулга	(76,999.98)	(230,999.94)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	856,674,095.67	678,448,329.40
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	947,586,130.03	770,329,473.76
Богино хугацаат өр төлбөр	-	-
Өглөг	-	-
Бусад өглөг	-	-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
Засгийн газрын оруулсан капитал	126,077,747.68	126,077,747.68
Өмнөх үеийн үр дүн	818,606,889.54	818,606,889.54
Тайлант үеийн үр дүн	-	(177,256,656.27)
Дахин үнэлгээний зөрүү	2,901,492.81	2,901,492.81
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	947,586,130.03	770,329,473.76
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	947,586,130.03	770,329,473.76

**"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТУГ-ЫН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**
2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Урсгал	339,433,823.00	420,793,300.00
Улсын төсвөөс	405,419,544.29	501,475,050.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	65,985,721.29	80,681,750.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон санхүүжилт	23,706,433.00	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	42,279,288.29	80,681,750.00
Бараа, ажил үйлчилгээний орлого	12,835,000.00	1,284,400.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	12,835,000.00	1,284,400.00
Үндсэн үйл ажиллагааны орлого		1,284,400.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,835,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	418,254,544.29	502,759,450.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	347,274,607.00	381,665,531.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	313,781,209.00	344,811,078.00
Цалин	313,781,209.00	344,811,078.00
Бусад нэмэгдлүүд		
Унаа, болон бусад нөхөн олговор		
Нийгмийн хамгааллын шимтгэл	33,493,398.00	36,854,453.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	28,164,392.00	31,128,163.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	21,973,318.00	24,233,143.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,511,239.00	2,825,770.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,144,661.00	3,498,133.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	535,174.00	571,117.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,329,006.00	5,726,290.00
Тогтмол зардал	13,942,960.00	14,840,000.00
Гэрэл цахилгааны зардал	4,959,670.00	4,726,721.00
Түлш, халаалтын зардал	7,254,061.00	8,177,771.00
Цэвэр, бохир усны зардал	1,729,229.00	1,935,508.00
Хангамж, бараа материалын зардал	3,648,462.00	7,591,118.00
Тээвэр, шатахууны зардал	100,000.00	400,000.00
Бичиг хэргийн материал	1,704,000.00	1,691,400.00
Шуудан холбооны зардал	1,178,312.00	4,249,955.00
Ном, хэвлэлийн зардал	-	150,000.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	530,000.00	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	136,150.00	1,099,763.00
Нормативт зардал	400,000.00	1,660,000.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	400,000.00	1,660,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,460,900.00	6,683,030.00
Багаж хэрэгсэл	-	223,220.00
Урсгал	2,460,900.00	6,459,810.00
Томилолт, зочны зардал	1,637,000.00	2,509,000.00
Дотоод томилолтын зардал	1,637,000.00	2,509,000.00
Гадаад томилолтын зардал	-	-
Гадаадын зочны зардал	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	13,813,532.00	42,116,806.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,813,532.00	40,116,806.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	2,000,000.00

Бараа үйлчилгээний бусад зардал	185,227,916.04	220,395,980.27
Бусад зардал	6,727,917.00	16,744,494.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	178,499,999.04	203,651,486.27
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,361,573.29	2,554,641.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,961,573.29	
Төвлөрүүлэн шилжүүлэг	4,961,573.29	654,641.00
Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	1,900,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	400,000.00	1,900,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	573,766,950.33	680,016,106.27
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(155,512,406.04)	(177,256,656.27)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(155,512,406.04)	(177,256,656.27)

**"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТУГ-ЫН
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	115,166,486.46	2,901,492.81	656,999,740.13	775,067,719.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	10,911,261.22		317,119,555.45	328,030,816.67
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,077,747.68	2,901,492.81	974,119,295.58	1,103,098,536.07
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(155,512,406.04)	(155,512,406.04)
				-
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,077,747.68	2,901,492.81	818,606,889.54	947,586,130.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн			(177,256,656.27)	(177,256,656.27)
				-
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,077,747.68	2,901,492.81	641,350,233.27	770,329,473.76

**"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТУГ-ЫН
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	382,520,541.29	504,326,681.00
Урсгал	316,534,820.00	420,793,300.00
Улсын төсвөөс	316,534,820.00	420,147,109.00
Нийгмийн даатгалын сангаас		2,851,631.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	65,985,721.29	80,681,750.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон санхүүжилт	23,706,433.00	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	42,279,288.29	80,681,750.00
Бараа, ажил үйлчилгээний орлого	-	8,165,188.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	6,880,788.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	-	1,284,400.00
Үндсэн үйл ажиллагааны орлого		1,284,400.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	382,520,541.29	512,491,869.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,158,968.00	484,511,508.00
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	324,375,604.00	384,517,162.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	293,130,932.00	347,662,714.00
Цалин	293,130,932.00	347,662,714.00
Бусад нэмэгдлүүд		
Унаа, болон бусад нөхөн олговор		
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,244,672.00	36,854,448.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	26,305,866.00	31,128,161.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,527,798.00	24,233,141.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,346,037.00	2,825,770.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,938,158.00	3,498,133.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	493,873.00	571,117.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,938,806.00	5,726,287.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	50,783,364.00	99,994,346.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,942,960.00	14,840,000.00
Гэрэл цахилгааны зардал	4,959,670.00	4,726,721.00
Түлш, халаалтын зардал	7,254,061.00	8,177,771.00
Цэвэр, бохир усны зардал	1,729,229.00	1,935,508.00
Хангамж, бараа материалын зардал	4,108,312.00	7,663,268.00
Бичиг хэргийн материал	2,000,000.00	1,795,400.00
Тээвэр, шатахууны зардал	100,000.00	400,000.00
Шуудан холбооны зардал	1,178,312.00	4,249,955.00
Ном, хэвлэлийн зардал	-	150,000.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	530,000.00	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	300,000.00	1,067,913.00
Нормативт зардал	400,000.00	1,660,000.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	400,000.00	1,660,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,460,900.00	7,490,030.00
Багаж хэрэгсэл	-	898,220.00
Урсгал	2,460,900.00	6,591,810.00
Томилолт, зочны зардал	1,637,000.00	2,509,000.00
Дотоод томилолтын зардал	1,637,000.00	2,509,000.00
Гадаад томилолтын зардал	-	-
Гадаадын зочны зардал	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	22,078,082.00	49,045,106.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,078,082.00	47,045,106.00

Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	2,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6,156,110.00	16,786,942.00
Бусад зардал	6,156,110.00	16,786,942.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,361,573.29	2,554,641.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,961,573.29	654,641.00
Төвлөрүүлэн шилжүүлэг	4,961,573.29	654,641.00
Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	1,900,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	400,000.00	1,900,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	380,520,541.29	487,066,149.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,000,000.00	25,425,720.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
Хөрөнгийн зардал	2,000,000.00	25,425,720.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,000,000.00	25,425,720.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,000,000.00	25,425,720.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,000,000.00)	(25,425,720.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТУГ-ЫН 2016 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН			-	
УРСГАЛ ЗАРДАЛ			-	
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,293,300.00	421,431,509.00	861,791.00	99.8
Бүлгийн дүнгээр хянагддаг зардлууд	363,714,800.00	362,853,009.00	861,791.00	99.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	311,746,800.00	311,719,401.00	27,399.00	100.0
Үндсэн цалин	311,746,800.00	311,719,401.00	27,399.00	100.0
Нэмэгдэл			-	
Унаа хоолны хөнгөлөлт			-	
Урамшуулал			-	
Гэрээт ажлын цалин			-	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,292,200.00	33,471,208.00	820,992.00	97.6
Тэтгэвэрийн даатгал	21,822,276.00	21,916,724.00	(94,448.00)	100.4
Тэтгэмжийн даатгал	2,493,972.00	2,561,037.00	(67,065.00)	102.7
ҮОМШӨ-ийн даатгал	3,117,468.00	3,299,413.00	(181,945.00)	105.8
Ажилгүйдлийн даатгал	623,496.00	433,408.00	190,088.00	69.5
Эрүүл мэндийн даатгал	6,234,988.00	5,260,626.00	974,362.00	84.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,840,000.00	14,840,000.00	-	100.0
Гэрэл цахилгаан	5,321,500.00	4,726,721.00	594,779.00	88.8
Түлш халаалт	7,495,300.00	8,177,771.00	(682,471.00)	109.1
Цэвэр бохир ус	2,023,200.00	1,935,508.00	87,692.00	95.7
Байрны түрээс			-	
Хангамж, бараа материалын зардал	326,800.00	313,400.00	13,400.00	95.9
Бичиг хэрэг	280,000.00	295,400.00	(15,400.00)	105.5
Тээвэр шатахуун			-	
Шуудан холбоо интернэтийн төлбөр			-	
Ном хэвлэл			-	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал			-	
Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	46,800.00	18,000.00	28,800.00	38.5
Нормативт зардал			-	
Эм, бэлдмэд, эмнэлгийн хэрэгсэл			-	
Хоол, хүнс			-	
Нормын хувцас зөөлөн эдлэл			-	
Эд хогшил, урсгал засварын зардал			-	
Багаж техник хэрэгсэл			-	
Тавилга			-	
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл			-	
Урсгал засвар			-	
Томилолт, зочны зардал	2,509,000.00	2,509,000.00	-	100.0
Гадаад албан томилолт			-	
Дотоод албан томилолт	2,509,000.00	2,509,000.00	-	100.0
Зочин хүлээн авах зардал			-	
Зардлын зүйл тус бүрээр хянагдах тогтмол зардлууд	58,578,500.00	58,578,500.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,578,500.00	56,578,500.00	-	100.0
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ			-	
Тээврийн хэрэгслийн татвар			-	
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			-	
Газрын төлбөр			-	
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			-	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			-	
Төсвийн хөрөнгөөр санхүүжих ХО барилга байгууламж			-	
Төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж			-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	422,293,300.00	421,431,509.00	861,791.00	99.8
Төсвөөс олгосон санхүүжилт	420,793,300.00	420,147,109.00	646,191.00	99.8
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,500,000.00	1,284,400.00	215,600.00	85.6
Туслах үйл ажиллагааны орлого				
Хөрөнгө оруулалтын санхүүжилт				
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт				
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
АЖИЛЛАГСАД БҮГД	35	35	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	34	34	-	100.0
Үйлчлэх ажилтан				
Гэрээт ажилтан				